



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/87/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баруун-Урт сум

2023 он

Дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Утас: 70518396
Аудитын менежер: Г.Даваа
Утас: 70512123
Ахлах аудитор: Н.Болдбаатар
Утас: 70512127

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.5.1 Завсрын аудитын талаар.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
5.1 Төлбөрийн акт	15
5.2 Албан шаардлага	15
5.3 Зөвлөмж	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2023.02.24 № 69

танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН БАРУУН-УРТ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
4 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Д.БАТТУЛГА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Төсвийн шинэчлэлийн хүрээнд багш, ажилчдад дата, сургалтын хэрэглэгдэхүүн, сургалт, эрүүл мэндийн үзлэг, үнэлгээний урамшууллыг олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 98 арга хэмжээг төлөвлөн, гүйцэтгэл 91.2 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна. Элсэлтийн ерөнхий шалгалтад 547.7 хувь буюу улсын дунджаас 8 хувийн илүү үнэлэгдэж аймагтаа тэргүүн байр эзэлсэн байна. Аймгийн Байгаль орчны газраас 3.0 сая төгрөгийн эко төсөл хэрэгжүүлжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:/Bichig hereg/2023/A4 toot

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>154,785,454.02</u>	<u>335,946,292.40</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	152,863,247.13
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	152,863,247.13
3121	Төгрөг	-	152,863,247.13
31211	Төрийн сангийн харилцах	-	152,863,247.13
33	АВЛАГА	48,672.00	1,226,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	48,672.00	-
33101	Цалингийн авлага		450,000.00
335	Бусад авлага	-	776,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага		776,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	154,736,782.02	181,857,045.27
351	Түүхий эд материал	551,529.60	-
35130	Эм боох материал	551,529.60	-
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	13,793,482.00	22,802,269.00
354	Хангамжийн материал	140,391,770.42	159,054,776.27
35410	Бичиг хэргийн материал	1,112,597.00	591,690.00
35420	Аж ахуйн материал	183,594.00	337,609.00
35450	Барилгын засварын материал	267,600.00	-
35470	Бусад хангамжийн материал	138,827,979.42	158,125,477.27
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,580,669,264.49</u>	<u>2,766,475,882.78</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,580,669,264.49	2,766,475,882.78
392	Биет хөрөнгө	2,469,145,264.57	2,654,603,216.22
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,463,800,823.84	2,463,800,823.84
39202	Хуримтлагдсан элэгдэл	(136,972,470.60)	(184,337,297.04)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	230,644,523.20	251,954,066.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	(217,891,550.49)	(31,623,234.93)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	201,594,483.52	199,569,548.57
39208	Хуримтлагдсан элэгдэл	(138,672,759.11)	(122,449,947.46)
39214	Бусад үндсэн хөрөнгө	18,545,000.00	17,225,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(14,246,167.09)	(9,501,833.76)
39217	Ном	62,343,381.30	69,966,090.30
393	Биет бус хөрөнгө	111,523,999.92	111,872,666.56
39301	Програм хангамж	1,508,000.00	3,008,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(354,000.08)	(1,505,333.44)
39303	Бусад биет бус хөрөнгө	110,920,000.00	110,370,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,735,454,718.51</u>	<u>3,102,422,175.18</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,864,915,942.35	2,701,810,865.75
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,502,114,384.35	468,423,996.05
120	Нийтлэг татварын бус орлого	91,963,584.35	232,349,396.05
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	91,963,584.35	232,349,396.05
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	7,994,535.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	34,335,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	91,963,584.35	190,019,860.55
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,410,150,800.00	236,074,600.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,410,150,800.00	236,074,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	362,801,558.00	2,233,386,869.70
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	1,676,856,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,676,856,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,522,358.00	-
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	800,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,572,158.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,150,200.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	345,279,200.00	556,530,669.70
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	345,279,200.00	556,530,669.70
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,831,758,154.06	2,348,968,068.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,831,758,154.06	2,348,968,068.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,780,751,677.99	2,165,689,851.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,169,338,812.00	1,420,588,350.72
210101	Үндсэн цалин	820,854,795.55	1,017,583,696.42
210102	Нэмэгдэл	259,098,607.80	345,818,736.07
210104	Урамшуулал	89,385,408.65	57,185,918.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,417,652.00	177,808,548.36
210201	Тэтгэврийн даатгал	110,135,400.00	122,049,536.76
210202	Тэтгэмжийн даатгал	9,758,000.00	14,111,655.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,726,100.00	11,471,428.31
210204	Ажилгүйдлийн даатгал	1,945,200.00	2,543,759.44
210205	Эрүүл мэндийн даатгал	21,852,952.00	27,632,168.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	319,079,600.00	360,863,657.18
210301	Гэрэл, цахилгаан	7,723,607.85	12,625,611.83
210302	Түлш, халаалт	301,267,000.00	326,610,460.00
210303	Цэвэр, бохир ус	10,088,992.15	21,627,585.35
2104	Хангамж, бараа материалын зардал	23,933,839.33	-
210401	Бичиг хэрэг	1,971,913.00	-
210402	Тээвэр, шатахуун	1,605,583.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,326,228.68	-
210404	Ном, хэвлэл	5,970,320.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	371,537.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,688,257.65	-

2105	Нормативт зардал	5,603,418.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,907,540.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	695,878.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,141,770.00	4,440,900.00
210604	Урсгал засвар	26,141,770.00	4,440,900.00
2107	Томилолт, зочны зардал	1,453,300.00	-
210702	Дотоод албан томилолт	1,453,300.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,098,660.00	21,329,179.05
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,098,660.00	7,994,535.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	13,334,644.05
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	81,684,626.66	180,659,216.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	83,021,516.75
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,418,066.40	18,593,590.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	71,266,560.26	79,044,109.46
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,006,476.07	183,278,217.11
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,006,469.35	182,793,611.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,365,000.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	47,641,469.35	160,278,311.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	22,515,300.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	484,606.11
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	484,606.11
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	6.72	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	6.72	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	33,157,788.29	352,842,797.12
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	52,116.80
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	52,116.80
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(52,116.80)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	33,157,788.29	352,790,680.32

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,772,952,358.00	2,511,791,005.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	42,329,535.50
120	Нийтлэг татварын бус орлого	-	42,329,535.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	42,329,535.50
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	7,994,535.50
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	34,335,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,772,952,358.00	2,469,461,469.70
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,410,150,800.00	2,059,604,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	2,059,604,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,410,150,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,522,358.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	800,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,572,158.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,150,200.00	-

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	345,279,200.00	409,857,369.70
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	345,279,200.00	409,857,369.70
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,762,875,887.00	2,255,693,687.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,762,875,887.00	2,255,693,687.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,710,644,480.28	2,072,269,044.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,167,731,000.00	1,422,147,490.72
210101	Үндсэн цалин	819,246,983.55	1,017,583,696.42
210102	Нэмэгдэл	259,098,607.80	345,818,736.07
210104	Урамшуулал	89,385,408.65	58,745,058.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,459,300.00	177,808,548.36
210201	Тэтгэврийн даатгал	110,135,400.00	122,049,536.76
210202	Тэтгэмжийн даатгал	9,758,000.00	14,111,655.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,726,100.00	11,471,428.31
210204	Ажилгүйдлийн даатгал	1,945,200.00	2,543,759.44
210205	Эрүүл мэндийн даатгал	21,894,600.00	27,632,168.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	319,079,600.00	348,972,898.83
210301	Гэрэл, цахилгаан	7,723,607.85	12,625,611.83
210302	Түлш, халаалт	301,267,000.00	326,610,460.00
210303	Цэвэр, бохир ус	10,088,992.15	9,736,827.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,312,917.68	-
210401	Бичиг хэрэг	2,099,961.00	-
210402	Тээвэр, шатахуун	1,605,583.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,284,618.68	-
210404	Ном, хэвлэл	5,805,200.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	371,537.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,146,018.00	-
2105	Нормативт зардал	6,444,899.60	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,131,299.60	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,313,600.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,199,600.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	26,199,600.00	5,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,453,300.00	-
210702	Дотоод албан томилолт	1,453,300.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,541,994.00	23,813,530.05
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,541,994.00	7,994,535.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	15,818,995.05
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,421,869.00	94,526,577.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	71,253,503.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,421,869.00	23,273,074.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,231,406.72	183,424,642.11
2132	Бусад урсгал шилжүүлэг	52,231,400.00	182,940,036.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,600,800.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	47,630,600.00	160,424,736.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	22,515,300.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6.72	484,606.11
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6.72	484,606.11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	10,076,471.00	256,097,318.13
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,076,471.00	103,234,071.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,076,471.00	103,234,071.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,076,471.00	103,234,071.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,076,471.00	103,234,071.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(10,076,471.00)	(103,234,071.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	152,863,247.13
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	152,863,247.13

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	132,444,000.00	3,423,822.44	2,597,979,084.07	0.00	2,733,846,906.51
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-	0.00	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	132,444,000.00	3,423,822.44	-137,426,962.44	0.00	-1,559,140.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.0	0.00	0.0
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	3,088,646,726.83	0.00	3,088,646,726.83
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	132,444,000.00	3,423,822.44	2,951,219,764.39	0.00	3,087,087,586.83

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

№	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,512,565,200.00	2,358,443,151.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,512,565,200.00	2,358,443,151.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,320,977,300.00	2,175,503,115.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,549,980,500.00	1,422,147,490.72
210101	Үндсэн цалин	1,141,420,900.00	1,017,583,696.42
210102	Нэмэгдэл	364,485,200.00	345,818,736.07
210104	Урамшуулал	44,074,400.00	58,745,058.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	194,665,800.00	177,808,548.36
210201	Тэтгэврийн даатгал	132,382,700.00	122,049,536.76
210202	Тэтгэмжийн даатгал	15,574,300.00	14,111,655.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,459,600.00	11,252,543.16
210204	Ажилгүйдлийн даатгал	3,113,600.00	2,762,644.59
210205	Эрүүл мэндийн даатгал	31,135,600.00	27,632,168.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	348,972,900.00	348,972,898.83
210301	Гэрэл, цахилгаан	8,500,000.00	12,625,611.83
210302	Түлш, халаалт	326,659,100.00	326,610,460.00
210303	Цэвэр, бохир ус	13,813,800.00	9,736,827.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,088,100.00	25,313,530.05
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,768,600.00	7,994,535.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,319,500.00	17,318,995.05
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	196,270,000.00	196,260,648.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	170,290,800.00	170,281,448.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,979,200.00	25,979,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	191,587,900.00	182,940,036.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	191,587,900.00	182,940,036.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	169,072,600.00	160,424,736.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,515,300.00	22,515,300.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,469,461,600.00	2,477,456,005.20
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,469,461,600.00	2,477,456,005.20
122005	Орон нутгийн төсвөөс	2,469,461,600.00	2,477,456,005.20
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		152,863,247.13

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь “Шинэ сэтгэлгээ шилдэг сургалт” зорилгын хүрээнд бүх талын хамтын ажиллагааг хангаж, сургалтын ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах 8 зорилтыг дэвшүүлэн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай”
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаал “Заавар батлах тухай”
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/259 дугаар тушаал “Заавар батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө дунд зэрэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 366,967.50 мянган төгрөгөөр буюу 11.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		152,863.20	152,863.20
Авлага	48.6	1,226.00	1,177.40
Бараа материал	154,736.80	181,857.10	27,120.30
Үндсэн хөрөнгө	2,580,669.30	2,766,475.90	185,806.60
Нийт хөрөнгө	2,735,454.70	3,102,422.20	366,967.50
Өр төлбөр	1,607.80	15,334.60	13,726.80
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,733,846.90	3,087,087.60	353,240.70
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,735,454.70	3,102,422.20	366,967.50

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 152,863.20 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд үлдэгдэл санхүүжилтийг төвлөрүүлээгүй нь нөлөөлжээ.
- Авлагын данс 1,177.40 мянган төгрөгөөр өссөн нь цалингийн урьдчилгаа олгож суутган тооцоогүй, эргэлтийн номын сангийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй авлагаар бүртгэсэн нь байна.
- Бараа материал данс 181,857.1 мянган төгрөг болж 27,120.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 240,766.6 мянга, үнэ төлбөргүй 28,351.1 мянга нийт 269,117.7 мянган төгрөгийн бараа материал авч 241,997.4 мянган төгрөгийн материал зарцуулсан нь нөлөөлсөн байна.
- Үндсэн хөрөнгө данс 3,115,893.5 мянган төгрөг болж 26,537.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвийн хөрөнгөөр 103,234.1 мянга, үнэ төлбөргүй 48,466.0 мянга нийт 103,234.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 23,785.7 мянган төгрөгийн хөрөнгө акталсан байна.
- Өр төлбөр дансны үлдэгдэл 13,726.8 мянган төгрөг болж өссөн нь Өсөхдэлгэр-Ундрах ххк-д бараа үйлчилгээний 2,667.8 мянга, Дөрвөлж ОНӨҮГ-т 11,890.7 мянган төгрөгийн цэвэр, бохир усны өр үүссэн байна.
- Засгийн газрын хувь оролцоо данс 353,240.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,029,642.6 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс улсын төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 2,469,461.5 мянган төгрөг батлагдсан байна. Энэ нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/122 дугаар тушаалын дагуу төрийн болон орон нутгийн өмчит ерөнхий боловсролын сургуулийн төрийн үйлчилгээний албан тушаалын цалинг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,756,207.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 280,235.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,059,604.1 мянга, орон нутгийн төсвөөс 409,857.4 мянга, өөрийн орлого 42,329.5 мянга нийт 2,511,791.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсвөөс 484.6 мянган төгрөгийг төвлөрүүлж, 152,863.2 мянган төгрөгийн харилцах дансанд үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,358,443.1 мянган төгрөг буюу 93.9 хувьтай зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт %
Орон нутгийн төсөв					
1	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	353,972.9	353,972.9	-	100
2	80112-Нийтлэг үйлчилгээ	55,884.5	55,399.9	484.6	99.1
	Дүн	409,857.4	409,372.8	484.6	99.9
Улсын төсөв					
1	80226-Байр ашиглалтын үйлчилгээ	6,927.8	6,927.8	-	100
2	80312-Сургалт семинар	3,464.0	3,463.1	0.9	99.9
3	81605-Эрүүл мэндийг дэмжих	7,966.9	7,966.9	-	100.0
4	81801-Үдийн цай хөтөлбөр	169,072.6	160,424.7	8,647.9	90.7
5	81806-Дотуур байрны үйлчилгээ	306.3	306.3	-	100.0
6	81816-"Зөв Монгол хүүхэд" үндэсний хөтөлбөр	80,920.0	80,920.0	-	100.0
7	81823-Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	15,587.5	15,587.5	-	100.0
8	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,604,541.6	1,466,229.9	138,311.7	91.4
9	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	170,817.5	164,915.0	5,902.5	96.6
10	81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчинг сайжруулах	35.0	35.0	-	100.0
11	81848-Сурах бичгийн түрээс	8,768.6	7,994.5	774.1	91.2
12	83602-ЗГ болон засаг даргын нөөц хөрөнгөөс хуваарилсан	34,300.0	34,299.6	0.4	100
	Дүн	2,102,707.8	1,949,070.3	153,637.5	98.48
	НИЙТ ДҮН	2,512,565.2	2,358,443.1	154,122.0	-

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Болдбаатар, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн № 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 1,831,758.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 27,476.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд уг зардлууд 41,784.0 мянган төгрөгөөр өссөн байна. Тухайлбал: гэрэл цахилгааны зардал 4,902.0 мянган төгрөгөөр, түлш, халаалт 25,343.4 мянган төгрөгөөр, цэвэр, бохир ус зардал 11,538.7 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Дээрх зардлууд өмнөх оноос нэмэгдсэн учир шалтгааныг авч үзвэл:

- *Өмнөх жил ковидын улмаас цахимаар хичээллэсэнтэй холбоотойгоор гэрэл, цэвэр бохир усны зардал гүйцэтгэлээр бага гарсан байна. Тухайн онд 3 ээлжээр хичээллэсэн, халаалтын сарыг 1 сараар нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.*

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан Шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллээс таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 10 зарлагын гүйлгээний 326.8 сая, урсгал санхүүжилтийн 24 гүйлгээний 721.9 сая төгрөгийг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 / тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;/ 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөв, иж бүрэн олон нийтэд ойлгомжтой www.shilendans.gov.mn цахим хуудсанд бүрэн гүйцэт мэдээлж байх албан шаардлага өгсөн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуульд завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	6,300.0	4	6,300.0	100
Нийт дүн	4	6,300.0	4	6,300.0	100

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 26,501.4 мянган төгрөгийн алдаа² илэрснээс аудитын явцад 1,226.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 25,275.4 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Үүнд:

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Цалингийн зардлаас урьдчилгаа олгож суутган тооцоогүй 450.0 мянган төгрөгийг шууд зардалд илэрхийлснийг,
- Эргэлтийн номын сангийн түрээсийн орлого 776.0 мянган төгрөгийг аккрузал сууриар хөтлөөгүйг залруулж авлагаар бүртгэв.

Аудитаар нийт 16,768.9 мянган төгрөгийн зөрчил³ илэрснээс, 2,210.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, шилэн дансны нэгдсэн сайтад мэдээллийг цаг хугацаанд нь мэдээлэх албан шаардлага хүргүүлж, 14,558.6 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Сахилгын шийтгэлтэй ажилтанд ур чадвар, үр дүнгийн урамшуулал 884.4 мянган төгрөгийг олгож, төсвийг илүү зарцуулсан.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах/, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1.4 /сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно/, Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.6 /төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно/, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.7 дахь заалттай нийцэхгүй байна.

5.1.2 Цалингийн зардлаас урьдчилгаа олгож 100.0 мянган төгрөгийг илүү суутгасан, 450.0 мянган төгрөгийг суутган тооцоогүй авлагаар илэрхийлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах/ дахь заалттай нийцэхгүй байна.

5.1.3 Эргэлтийн номын сангийн түрээсийн орлого 776.0 мянган төгрөгийг бүрэн төвлөрүүлээгүй, авлагаар илэрхийлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 41 дүгээр зүйлийн 41.2.1 /хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх/, 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах/ дахь заалттай нийцэхгүй байна.

5.2 Албан шаардлага

5.2.1 Шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллээс таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 10 зарлагын гүйлгээний 326.8 сая, урсгал санхүүжилтийн 24 гүйлгээний 721.9 сая төгрөгийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 / тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;/ 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дэх заалтуудыг зөрчсөн байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Аж ахуйн нэгжээс 11,890.7 мянган төгрөгийн цэвэр, бохир усны төлбөр , 2.667.8 мянган төгрөгийн аж ахуйн материал худалдан авч төсвийн хүрээнд зарлага гаргах болон өр төлбөрийг зохистой удирдаагүй байна. Энэ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;/, 6.4.8 /төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5./дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах/, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 4.11 дэх заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн хууль, холбогдох заавар журам, Төсвийн тухай хуулийг мөрдөж өр төлбөр үүсгэхгүй төсвийг зохистой удирдан, үлдэгдэл өр төлбөрийг барагдуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Урьдчилгааг шууд зардалд илэрхийлсэн	1	450.0			1	450.0	1	450.0				
Эргэлтийн номын сангийн түрээсийн орлогыг бүртгээгүй	1	776.0	1	776.0			1	776.0				
Нярав бараа материалын тайланг үнэн зөв бэлтгэж толилуулаагүй	1	25,275.40	1	25,275.4					1	25,275.4	1	25,274.4
Дүн	3	26,501.4	2	26,051.4	1	450.0	2	1,226.0	1	25,275.4	1	25,274.4

урамшуулал олгосон										
Урьдчилгаа олгоод илүү, дутуу суутгасан	1	550.0	1	550.0	-	-	-	-	-	-
Эргэлтийн номын сангийн түрээсийн орлого төвлөрүүлээгүй	1	776.0	1	776.0	-	-	-	-	-	-
Төсвийг хэтрүүлэн зарцуулж өр төлбөр үүсгэсэн	1	14,558.5	-		-	-	1	14,558.5	-	-
Дүн	3	16,768.90	3	2,210.40	-	-	1	14,558.50	-	-